**БАЯНХОНГОР АЙМГИЙН**
**ӨЛЗИЙТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН**
**ЗАХИРАМЖ**

2022 оны 05 сарын 31 өдөр Дугаар А/64 Улаан-Уул

Автомашин тээврийн хэрэгсэлгүй
өдөр болгох тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, автозамын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.8, Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.4.5 дах заалтууд Аймгийн Засаг даргын 2022 оны А/351 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдрийг тэмдэглэн өнгөрүүлэхтэй холбогдуулан 2022 оны 06 дугаар сарын 01-ны өдрийн 09:00 цагаас 20:00 цаг хүртэл хугацаанд автомашин тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг түр хязгаарласугай.

2.Хязгаарласан замын зураглалыг хавсралтаар батлаж, автомашин тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг түр хязгаарласан хугацаанд хамгаалалтын болон нэмэлт тэмдэг, тэмдэглэгээг, төв замд байрлуулах, иргэдийг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, нийгмийн хэв журам сахиулан, олон нийтийн аюулгүй байдлыг хангаж архи согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэхийг хориглож, архи, согтууруулах ундааг тоолж лацдахыг сумын цагдаа, цагдаагийн ахлагч (Г.Өнөболд)-д үүрэг болгосугай.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч (Г.Баттогтох)-д даалгасугай.

ДАРГА Т.ЭРДЭНЭБАТ

642201109

Сумын Засаг дарга 2022 оны 05
дугаар сарын 31-ны өдрийн А/164
дугаар захирамжийн хавсралт

## АВТО МАШИН, ТЭЭВРИЙН ХЭРЭГСЛИЙН ХӨДӨЛГӨӨН ХЯЗГААРЛАХ ЗАМЫН ЗУРАГЛАЛ




---oOo---